

ЭНЭРЭЛ ДЭЭД СУРГУУЛЬД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэрэл дээд сургууль (цаашид ЭДС гэнэ) нь оюутан элсүүлэхэд Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2022 оны А/540 дүгээр тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2023 оны А/97 дугаар тушаалаар батлагдсан “Босго оноо тогтоох тухай”, бусад холбогдох эрх зүйн акт болон энэхүү журмыг үндэслэн үйл ажиллагаандаа баримтлан ажиллана.

1.2 Элсэлтийн үйл ажиллагааг ил тод, шударга зохион байгуулна.

1.3 ЭДС-ийн элсэлтийн журам, суралцах хөтөлбөр, ЭЕШ-ын оноо тооцох болон элсэлттэй холбоотой бусад мэдээллийг www.enerel.edu.mn цахим хуудсанд байршуулна.

1.4 Улаанбаатар хот болон орон нутгаас элсүүлэх оюутны хяналтын тоог ЭДС-ийн захиргааны зөвлөлийн саналыг үндэслэн Удирдах зөвлөл тогтооно.

1.5 ЭДС-тай хамтын ажиллагааны гэрээний дагуу суралцах гадаад иргэдийг ЭДС-ийн захирлын тушаалаар шууд элсүүлэн суралцуулж болно.

1.6 Удирдах зөвлөлөөс батласан хяналтын тоонд багтаан элсэлтийн үйл ажиллагааг жилд 2 удаа зохион байгуулж болно.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА

2.1 ЭДС-ийн Захирлын тушаалаар батлагдсан Элсэлтийн комисс (цаашид ЭК гэнэ) Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 13-р хорооны нутаг дэвсгэрт байрлах өөрийн сургуулийн байрандаа болон хөдөө орон нутагт итгэмжлэгдсэн бие төлөөлөгчөөр дамжуулан элсэгчдийн хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, элсүүлэх ажлыг зохион байгуулна.

2.2 ЭК нь энэхүү журмыг баримтлан комиссын гишүүдийн ажил үүргийн хуваарилалт, элсэлтийн үед баримтлах дэг журам, элсэхийг хүсэгчдийн материалыг шалгах болон өргөдөл гомдлыг барагдуулах, элсэлтийн явцад хяналт тавих, журмаар зохицуулаагүй асуудлыг хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.3 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан оюутны хяналтын тоонд нийцүүлэн өөрийн байгууллагын материаллаг бааз, зөвшөөрөлд заагдсан мэргэжлүүдийн дагуу оюутан элсүүлнэ.

ГУРАВ. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1 ЭДС-д элсэх хүсэлт гаргасан байх

3.2 Бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой байх;

3.3 Элсэлтийн ерөнхий шалгалтын (ЭЕШ) Боловсролын Үнэлгээний Төвийн (БҮТ) хүчин төгөлдөр батламжтай эсвэл гадаадын улс орны ерөнхий боловсролын шалгалтын оноог БҮТ-өөр дүйцүүлсэн батламжтай байх;

3.4 Тухайн хөтөлбөрт шаардагдах хичээлээр ЭЕШ-ын үндэсний хэмжээний босго оноог хангасан байх;

3.5 Элсэн суралцах мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/-ээр 5-аас доошгүй жил ажилласан, 30-аас дээш насны иргэн ЭЕШ-ын шалгалтгүй элсүүлэх;

3.6 Их дээд сургууль, коллеж төгссөн элсэгчдийн диплом Дээд боловсролын удирдлага мэдээллийн систем /ДБУМС/-д бүртгэлтэй байх;

ДӨРӨВ. ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Элсэлтийн үйл ажиллагааг дараах үе шатаар зохион байгуулна. Үүнд:

4.1 Элсэгчдэд мэдээлэл дамжуулах

- 4.1.1 Телевиз;
- 4.1.2 Радио;
- 4.1.3 Веб сайт болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
- 4.2 Элсэгчдийг бүртгэх
 - 4.2.1 Цахим хуудсаар
 - 4.2.2 ЭДС-ийн ЭК-ын нарийн бичиг
 - 4.2.3 Орон нутагт томилолтоор ажилласан ЭДС-ийн ЭК-ын гишүүн багш
- 4.3 Бүртгүүлэгчдийг эрэмбэлэх
 - 4.3.1 Мэргэжлийн хөтөлбөр
 - 4.3.2 Дамжаа
 - 4.3.3 Анги, бүлгээр эрэмбэлэх
- 4.4 Бүртгүүлэгчдийг мэдээллээр хангах
 - 4.4.1 ЭДС-ийн Элсэлтийн хөтөчтэй танилцах
- 4.5 Суралцагчдийг баталгаажуулах
 - 4.5.1 ЭДС-ийн захирлын тушаалаар
 - 4.5.2 Үүлэн программаар
 - 4.5.3 БШУЯ-ны ДБУМ-ын программаар

ТАВ. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

- 5.1. Цахим хуудсаар элсэгчдийг хүсэгчдийн 6 сарын 15-аас 7 сарын 8-ны өдрүүдэд <http://enerel.edu.mn/elseltanket.docx> хаягнаас анкет татан авч info@enerel.edu.mn хаягруу илгээн бүртгүүлж болно.
- 5.2. ЭК нь 07-р сарын 9, 08-р сарын 26-нд тус тус элсэгчдийн жагсаалтыг гаргаж, мэдээллийг сургууль дээр болон сургуулийн веб сайт <http://www.enerel.edu.mn> дээр танилцуулна.
- 5.3. ЭДС нь 06-р сарын 20-оос 10-р сарын 15-ны өдрүүдэд үндсэн элсэлтийн бүртгэлийг авч, нэмэлт элсэлтийг 12-р сарын 15-аас 01-р сарын 31-ны хооронд бүртгэл явагдана.
- 5.4. Бүртгүүлэгч нь хэдэн ч хөтөлбөрт бүртгүүлж болох ба бүртгэлийн хураамж 15,000₮ байна. Бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.
- 5.5. ЭДС-д эм зүй хөтөлбөрөөр бүртгүүлэгчдийн хими, математикийн аль нэг нь 480-ээс дээш оноотой, бусад хөтөлбөрөөр бүртгүүлэгчдийн 1-р хичээл хими, математикийн аль нэг нь 400-ээс дээш оноотой, 2-р хичээл бусад хичээлүүд эсвэл ур чадвар 480-аас дээш оноотой байна.
- 5.6. Бүртгүүлэгчдийн оноогоор нь байр эзлүүлэх бөгөөд оноо тэнцсэн тохиолдолд Боловсролын үнэлгээний дундаж оноогоор харьцуулан жагсаана.
- 5.7. Тухайн мэргэжилд бүртгүүлэгчдийг онооны дарааллаар хяналтын тоонд багтаан суралцах эрхийг баталгаажуулна.

ЗУРГАА. ХӨНГӨЛӨЛТТЭЙ НӨХЦӨЛӨӨР ЭЛСҮҮЛЭХ

- 6.1 2022-2023 оны хичээлийн жилд хими, биологийн улс аймгийн олимпиадад 1-4-р байр эзэлсэн, Олон улсын олимпиадад шагналт байранд шалгарсан сурагчдийг элсүүлэх ба төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх,
- 6.2 Анагаах ухааны их дээд сургуульд хүний их эмч мэргэжлээр төгссөн, магистрт суралцсан, нарийн мэргэжил эзэмшсэн элсэгчдийг нийгмийн эрүүл мэнд судлалч, эрүүл ахуйч, эм зүйн 4-р дамжаанд элсүүлнэ.
- 6.3 Анагаахын бусад мэргэжлээр бакалаврын болон дипломын зэрэгтэй мэргэжилтэнг ЭДС-ийн тусгай зөвшөөрөлд дурдагдсан мэргэжлүүдээр 3-р дамжаанд элсүүлнэ.
- 6.4 Анагаахын бус их дээд сургууль коллеж төгссөн бакалаврын болон дипломын зэрэгтэй мэргэжилтэнг ЭДС-ийн тусгай зөвшөөрөлд дурдагдсан мэргэжлүүдээр 2-р дамжаанд элсүүлнэ.
- 6.5 Туслах сувилагчаас төгсөгчдийг сувилагчийн 2-р дамжаанд элсүүлнэ.
- 6.6 ЭДС-ийн эм найруулагч мэргэжлээр төгсөгчдийн эм зүйн 4-р дамжаанд элсүүлнэ.

ДОЛОО. СУРАЛЦАГЧДЫН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛАЛ

7.1 Төрөөс олгогдож буй буцалтгүй тэтгэлэг

7.1.1 Сувилагч мэргэжлээр элсэгчдэд

7.1.1.1 Голч оноо 3.0 ба түүнээс дээш тохиолдолд - 100%

7.1.1.2 Голч оноо 2.7- 2.9 байгаа тохиолдолд - 70%

7.2 Оюутны хөгжлийн хүүгүй зээл

7.2.1 Сургалтын зээл /Төгсөөд 4-6 жилд хуваан хүүгүй төлөх зээл/

7.3 Боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламж

7.3.1 Бүтэн өнчин суралцагч

7.3.2 Эцэг эхийн аль нэг нь хөгжлийн бэрхшээлтэй

7.3.3 Элсэн суралцагч өөрөө хөгжлийн бэрхшээлтэй зэрэг тохиолдолд бүрэн хамрагдана.

7.4 Суралцах хугацаандаа сургуулиас олгох урамшуулал

7.4.1 Сувилагч мэргэжлээр ЭЕШ-ийн босго оноотой элсэгчид 1-р дамжааны эхний улиралд үнэгүй суралцана.

7.4.2 Олон улсын тэмцээн уралдаанд 1-р байр эзэлсэн тохиолдолд 1 жилийн сургалтын төлбөрийг 50%,

7.4.3 4 улирал дараалан А үнэлгээтэй суралцвал сургалтын төлбөрийг 20%

7.4.4 6-8 улирал дараалан А үнэлгээтэй суралцвал сургалтын төлбөрийг 40%

7.4.5 Шилдэг оюутанд үүсгэн байгуулагчийн тэтгэлэг олгоно.

7.4.6 Нэг гэр бүлээс тус сургуульд 2 оюутан суралцдаг бол нэг оюутны сургалтын төлбөрийг 1 удаа - 50%

НАЙМ. ГАДААД ЭЛСЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

8.1 Төгсөлтийн өмнөх сургалтад суралцах гадаадын иргэн жил бүрийн 04 дүгээр сарын 01-ээс 06 дугаар сарын 15-ны хооронд хүсэлтээ цахимаар гаргана.

8.2 Гадаад иргэн нь ЭДС-ийн вэб хуудсанд байршуулсан өргөдлийн маягт, эрүүл мэндийн хуудсыг бөглөж, дараах баримтын хамт илгээнэ.

- Гадаад иргэний үнэмлэх (Identification card), гадаад паспорт болон түүнтэй адилтгах бичиг баримт (хүчинтэй хугацаа 3-аас дээш жил)
- Боловсролын түвшинг илтгэх диплом (гэрчилгээ), дүнгийн хавсралтыг англи болон монгол хэл рүү орчуулсан орчуулгын хамт
- Англи хэлний мэдлэг, чадварыг илтгэх (TOEFL, IELTS, TOEIC зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх) баримт монгол хэлээр суралцах бол монгол хэлний шалгалтын дүн
- Цээж зураг (3,5x4,5 хэмжээтэй, сүүлийн 3 сарын дотор авхуулсан байх)
- Эрүүл мэндийн хуудас (сэтгэцийн эмчийн дүгнэлт, HIV, HBV, HCV, TPNA, ТВ шинжилгээнд сүүлийн 3 сар дотор хамрагдсан байх)

8.3 Суралцах хүсэлт гаргасан гадаад иргэнд ажлын 10 хоногт багтаан хариуг холбогдох хаягаар хүргүүлнэ.

8.4 Суралцах эрх авсан гадаадын иргэн тухайн хичээлийн жил эхлэхээс 14 хоногийн өмнө дараах материалыг эх хувиар авч ирж бүртгүүлнэ. Үүнд:

- Гадаад иргэний үнэмлэх (Identification card), гадаад паспорт болон түүнтэй адилтгах бичиг баримт (хүчинтэй хугацаа 3-аас дээш жил)
- Боловсролын түвшинг илтгэх диплом (гэрчилгээ), дүнгийн хавсралтыг англи болон монгол хэл рүү орчуулсан орчуулгын хамт
- Англи хэлний мэдлэг, чадварыг илтгэх (TOEFL, IELTS, TOEIC зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх) баримт монгол хэлээр суралцах бол монгол хэлний шалгалтын дүн
- Цээж зураг (3x4 хэмжээтэй, сүүлийн 3 сарын дотор авхуулсан байх)
- Эрүүл мэндийн хуудас (сэтгэцийн эмчийн дүгнэлт, HIV, HBV, HCV, TPNA, ТВ шинжилгээнд сүүлийн 3 сар дотор хамрагдсан байх)

- Амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамрагдсан баримт (Монгол улсын даатгалд заавал хамрагдсан байх)
- Бүртгэлийн хураамж төлсөн баримт (тухайн өдрийн Монгол банкны ханшаар байх)

ЕС. ЭЛСЭГЧДИЙН БҮРТГЭЛ БАТАЛГААЖУУЛАЛТ

9.1 Шалгалтын дүнгээр болзол хангасан элсэгчдэд 08-р сарын 15-24-ны хооронд сургууль дээр биеэр ирж бүртгүүлэн суралцах гэрээ байгуулан сургуулийн тодоод системд бүтргэж, ДБУМС-д баталгаажуулалт хийнэ.

9.2 Элсэгчдийн бичиг баримт нь зөрчилгүй байх шаардлагатай.

9.3 Элсэгчид бүртгэлээ баталгаажуулахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлэх шаардлагатай. Үүнд:

9.3.1 Бүрэн дунд боловсролын гэрчилгээ түүнтэй адилтгах бичиг баримт эх хувиараа мөн нотариатаар баталгаажуулсан хуулбар

9.3.2 Сурагчийн хувийн хэрэг

9.3.3 Иргэний үнэмлэхний баталгаажуулсан хуулбар

9.3.4 3*4 хэмжээтэй 4 хувь цээж зураг

9.3.5 Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж

9.3.6 Сургалтын төлбөр төлсөн баримт

9.3.7 Эрүүл мэндийн дэвтрийн хуулбар

9.3.8 Сургуульд орохыг хүссэн өргөдөл

9.4 Элсэлтийн хяналтын тоонд багтсан боловч бүртгэлээ баталгаажуулаагүй элсэгчийг суралцахаас татгалзсан гэж үзэн орон тоонд нөхөж элсэлт авна.

АРАВ. БУСАД

10.1 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийг үндэслэн дараах тохиолдолд ЭЕШ-ийн оноогүй элсүүлэн суралцуулж болно.

10.1.1 Дээд боловсролтой буюу дипломын голч дүн 2,8 ба түүнээс дээш бол,

10.1.2 Дипломын боловсролтой иргэн мэргэжлийн чиглэлийн дагуу шаталсан бакалаврын хөтөлбөрт элсэх

10.1.3 Бакалаврын болон техникийн боловсрол эзэмшсэн иргэн дипломын хөтөлбөрт элсэх

10.2 Тодорхой мэргэжлийн хөтөлбөрт нэмэлт элсэлтийг хяналтын тоонд багтаан хот, орон нутаг харгалзахгүйгээр ЭЕШ-ийн оноогоор жагсаан элсүүлнэ.

10.3 Ур чадварын шалгалтын хэлбэрийг элсэлтийн комисс шийдвэрлэнэ.

10.4 ЭДС-ийн оюутан элсүүлэх шаардлагыг хангаагүй боловч хичээл сонгон судлах хүсэлт гаргасан иргэнийг “Иргэнээр суралцагч” гэж бүтргэж болно.

10.4.1 Иргэнээр суралцагч нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэн байх ба тухайн хичээлийн жилд 25-30 багц цагийн хичээлийг судална.

10.4.2 Иргэнээр суралцагч нь оюутны хөгжлийн зээл болон буцалтгүй тусламжинд хамрагдах боломжгүй.

10.4.3 Иргэнээр суралцагч нь тус журмын гуравдугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан тохиолдолд “Оюутан”-аар бүтргэж, үргэлжлүүлэн суралцуулна.

10.4.4 Иргэнээр суралцагч нь “Оюутан”-аар бүтргэгдсэн өдрөөс эхлэн холбогдох дүрэм, журмын дагуу оюутны хөгжлийн зээл, буцалтгүй тусламжинд хамрагдах эрх нээгдэнэ.

10.5 Шинэ элсэгчдийн удиртгал хичээлийг 8 дугаар сарын сүүлийн 7 хоногт зохион байгуулна.

10.6 Шинээр элссэн оюутнууд эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.

10.7 Элсэгч нь элссэн хуваарь хүчингүй болгосон тохиолдолд сургалтын төлбөрийн 10%-ийг үйл ажиллагааны зардалд тооцож суутгал хийж, бичиг баримтыг буцаан олгоно.

10.8 Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн 1 багц цагийн үнэлгээ 110,000 төгрөг байх ба тухайн хичээлийн жилд судлах 25-30 багц цагаар үржүүлэн тооцно.

10.9 Сургалтын төлбөрийг жилээр болон улирлаар төлж болно.

**БАКАЛАВРЫН БОЛОН ДИПЛОМЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАХЫГ
ХҮСЭГЧДИЙН ЭЛСЭЛТИЙН ОНОО ТООЦОХ ХИЧЭЭЛИЙН ЖАГСААЛТ**

| № | Хөтөлбөрийн индекс | Хөтөлбөрийн нэр | Сургалтын хэлбэр | Элсэгчдийн боловсролын түвшин | Суралцах хугацаа | Дипломын зэрэг | ЭЭШ-ын 1-р хичээл, босго оноо | ЭЭШ-ын 2-р хичээл, босго оноо |
|----|--------------------|---------------------------------------|------------------|-------------------------------|--------------------|----------------------|--|--|
| 1 | D091601 | Эм зүй | Өдөр | Бүрэн дунд | 4 жил | Бакалавр | Хими, математикийн хичээлийн аль нэгээр 480-аас дээш оноотой байх | Бусад хичээлээр 480-аас дээш эсвэл ур чадварын 480-аас дээш оноотой байх |
| 2 | D098801 | Нийгмийн эрүүл мэнд | Өдөр | Бүрэн дунд | 4 жил | Бакалавр | Хими, нийгэм судлалын хичээлийн аль нэгээр 480-аас дээш оноотой байх | |
| 3 | D091301 | Сувилахуй | Өдөр Өдөр | Бүрэн дунд Диплом | 4 жил 1-1.5 жил | Бакалавр Бакалавр | Хими, математикийн хичээлийн аль нэгээр 400-аас дээш оноотой байх | |
| 4 | D091302 | Эх барихуй | Өдөр Өдөр | Бүрэн дунд Диплом | 4 жил 1-1.5 жил | Бакалавр Бакалавр | | |
| 5 | C091202 | Дүрс оношлогооны техникч | Өдөр | Бүрэн дунд | 3 жил | Диплом | | |
| 6 | C091302 | Эх баригч | Өдөр | Бүрэн дунд | 3 жил | Диплом | | |
| 7 | C091202 | Бага эмч | Өдөр | Бүрэн дунд | 2-3 жил | Диплом | | |
| 8 | C091301 | Сувилахуй | Өдөр | Бүрэн дунд | 2 жил | Диплом | | |
| 9 | C091702 | Уламжлалт анагаахын сувилагч | Өдөр | Бүрэн дунд | 3 жил | Диплом | | |
| 10 | C091602 | Эм найруулагч | Өдөр | Бүрэн дунд | 3 жил | Диплом | | |
| 11 | C091203 | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт | Өдөр | Бүрэн дунд | 3 жил | Диплом | | |

Сургуулийн хаяг: УБ хот, ЧД, 13-р хороо, Энэрэл ДС-н байр 17-р сургуулийн автобусны буудал
Харилцах утас: 89980895, 88046875, 90707580